



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/185

Булган

┌ Тусгай зөвшөөрөл шинээр олгох, ┐  
сунгах тухай


Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.13 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 дугаар тушаал, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2019 оны 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авч байгаа болон сунгах байгууллагуудын нэрийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авч байгаа болон сунгаж байгаа байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох хууль тогтоомж, тушаал, зааварт тусгагдсаны дагуу хяналт тавьж, зөрчил дутагдал үүсэхээс сэргийлэх, үүссэн дарууд холбогдох арга хэмжээг авч ажиллахыг комисс /С.Нарантуяа/-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд холбогдох хууль, тогтоомж, тушаал, зааврыг баримтлан хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /Б.Эрдэнэбаатар/, Мэргэжлийн хяналтын газар /С.Батболд/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190187

Аймгийн Засаг даргын 2019 оны  
04 дугаар сарын 05-ны өдрийн  
04 дугаар захирамжийн хавсралт

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР АВАХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл олгох хугацаа	Үйл ажиллганы чиглэл
1	Булган сумын "Өвөр Булган уул" ХХК	3 жил	Эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, ортопед болон тусгай хэрэгсэл ханган нийлүүлэх
2	Хишиг-Өндөр сумын "Хульж-Очир" ХХК-ийн "Очир" эмийн сан	3 жил	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүнээр үйлчлэх

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Тусгай зөвшөөрөл эхлэх хугацаа	Тусгай зөвшөөрөл дуусах хугацаа
1	Булган сумын "СХМ" ХХК-ийн "Таван-Од" эмийн сан	5 жилээр	2019/03/18	2024/03/18
2	Орхон сумын "Саранмичид" ХХК-ийн Эмийн эргэлтийн сан	5 жилээр	2019/03/18	2024/03/18
3	Бүрэгхангай сумын "Дархан сүлд" ХХК-ийн эмийн сан	5 жилээр	2019/03/18	2024/03/18